

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2025 оны сарын өдөр

Дугаар

Улаанбаатар хот

“Даатгалын багц дүрэм”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.2.3, 6.2.4, Захиргааны ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.7, Даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3, 14 дүгээр зүйлийн 14.1, 14.2, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 6 дугаар зүйлийн 6.1, 6.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 66 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн гуравдугаар хавсралт “Даатгалын нөөц сан, албан журмын даатгалын сан болон бусад санг бүрдүүлэх, хуваарилах, түүнд хяналт тавих журам”-ын 2.5¹.1, 2.5¹.2, 2.5¹.3 дахь заалт, “Даатгалын багц дүрэм”-ийн арван долоодугаар хавсралт “Даатгагчийн баталгаа гаргах үйл ажиллагааны журам”-ын 2.6 дахь хэсэг, доор дурдсан агуулгаар тус тус нэмсүгэй:

1/“Даатгалын багц дүрэм”-ийн гуравдугаар хавсралт “Даатгалын нөөц сан, албан журмын даатгалын сан болон бусад санг бүрдүүлэх, хуваарилах, түүнд хяналт тавих журам”-ын 2.5¹.1, 2.5¹.2, 2.5¹.3 дахь заалт:

“2.5¹.1. Даатгагч тайлант хугацаанд гаргасан нийт баталгааны шимтгэлийн орлогын 50-аас доошгүй хувиар баталгааны нөөц санг улирал бүр нэмж байгуулах бөгөөд тус нөөц санг энэ журмын 2.1.4-т заасан тусгай нөөц санд тусгайлан бүртгэнэ.”

“2.5¹.2. Баталгааны тусгай нөөц санг даатгагчийн хүчин төгөлдөр баталгааны гэрээнүүдийн хувьд өмнөх тайлант хугацааны эцэс дэх нөөцийн дүн болон тайлант хугацаанд шинээр байгуулсан даатгалын гэрээнд хамаарах нөөцийн нийлбэрээс тус хугацаанд зарцуулсан нөөцийн дүнг хасаж тооцно.

$$БНt = А + Б - В$$

Үүнд:

БНt – Тайлант хугацааны баталгааны тусгай нөөц сан;

А - Даатгагчийн хүчин төгөлдөр даатгалын баталгааны гэрээнүүдийн хувьд өмнөх тайлант хугацааны эцэс дэх дүн;

Б – Тайлант хугацаанд шинээр байгуулсан даатгалын баталгааны дүн;

В- Тайлант хугацаанд зарцуулсан нөөцийн дүн.”

“2.5¹.3.Даатгагч нь энэ журмын 2.5¹.1-д заасан баталгааны тусгай нөөц сангаас зарцуулалт хийсэн тохиолдолд энэ талаарх мэдэгдлийг ажлын 3 өдрийн дотор Хороонд мэдэгдэх бөгөөд мэдэгдэлд тусгай нөөц санг зарцуулах үндэслэл, хэмжээ, тооцоолол, тайлбарыг тодорхой тусгасан байна.”

2/“Даатгалын багц дүрэм”-ийн арван долоодугаар хавсралт “Даатгагчийн баталгаа гаргах үйл ажиллагааны журам”-ын 2.6 дахь хэсэг:

“2.6.Даатгагчийн гаргах баталгааны нийт дүн энэ журмын 2.2-т заасан хэмжээнээс хэтрэхгүй байх бөгөөд энэ хэмжээнээс хэтэрсэн бол тухайн давсан хэсгийг давхар даатгуулж, эрсдэлийн үнэлгээ хийсэн байна.”

2.Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 66 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн арван долоодугаар хавсралт “Даатгагчийн баталгаа гаргах үйл ажиллагааны журам”-ын 2.4.1 дэх заалтын “Даатгалын багц дүрмийн” гэсний өмнө “Өмнөх тайлант үед” гэж нэмсүгэй.

3.Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 66 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн гуравдугаар хавсралт “Даатгалын нөөц сан, албан журмын даатгалын сан болон бусад санг бүрдүүлэх, хуваарилах, түүнд хяналт тавих журам”-ын 2.5.5 дахь заалт, “Даатгалын багц дүрэм”-ийн арван долоодугаар хавсралт “Даатгагчийн баталгаа гаргах үйл ажиллагааны журам”-ын 2.2, 2.4.3 дахь хэсэг, “Даатгалын багц дүрэм” -ийн аравдугаар хавсралт “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчоос тайлан, мэдээ, өргөдөл гаргах заавар”-ын 2.2.1 дахь заалтад доор дурдсан агуулгаар тус тус өөрчлөн найруулсугай:

1/ “Даатгалын багц дүрэм”-ийн гуравдугаар хавсралт “Даатгалын нөөц сан, албан журмын даатгалын сан болон бусад санг бүрдүүлэх, хуваарилах, түүнд хяналт тавих журам”-ын 2.5.5 дахь заалт:

“2.5.5.Даатгагч энэ журмын 2.5¹.3-т зааснаас бусад тохиолдолд тусгай нөөц сангаас зарцуулалт хийхээр бол Хороонд хүсэлтээ бичгээр тавих ба хүсэлтэд тусгай нөөц санг зарцуулах үндэслэл, хэмжээ, тооцоолол, тайлбарыг тодорхой тусгасан байна.”

2/ “Даатгалын багц дүрэм”-ийн арван долоодугаар хавсралт “Даатгагчийн баталгаа гаргах үйл ажиллагааны журам”-ын 2.2, 2.4.3 дахь заалт:

“2.2.Даатгагчийн гаргаж болох баталгааны нийт дүн нь даатгагчийн өөрийн хөрөнгийн дүнгийн 70 хувь дээр баталгааны тусгай нөөц санг нэмэгдүүлсэн дүнгээс хэтрэхгүй бөгөөд дараах томъёогоор тооцно:

$$ДБ=(ДӨХ*70\%)+БН$$

ДБ – даатгагчийн гаргаж болох баталгааны нийт дүн

ДӨХ – даатгагчийн өөрийн хөрөнгийн дүн

БН – баталгааны тусгай нөөц сан”

“2.4.3. “Даатгалын багц дүрэм”-ийн гуравдугаар хавсралт “Даатгалын нөөц сан, албан журмын даатгалын сан болон бусад санг бүрдүүлэх, хуваарилах, түүнд хяналт тавих журам”-д заасны дагуу баталгааны нөөц санг байгуулах;”

3/ “Даатгалын багц дүрэм” -ийн аравдугаар хавсралт “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчоос тайлан, мэдээ, өргөдөл гаргах заавар”-ын 2.2.1 дахь заалт

“2.2.1.Ердийн даатгагч нь Нягтлан бодох бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан маягтаар (Санхүүгийн байдлын тайлангийн Даатгалын нөөц сан хэсэгт “Баталгааны тусгай нөөц сан”, “Тусгай нөөц сангийн бусад хэсэг” гэсэн мөрүүдийг нэмж гаргана.);”

4.Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 66 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн арван долоодугаар хавсралт “Даатгагчийн баталгаа гаргах үйл ажиллагааны журам”-ын 2.1.2.4 дэх заалтын “эрсдэлийн” гэснийг “тусгай нөөц” гэж өөрчилсүгэй.

5.Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 66 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн аравдугаар хавсралт “Даатгагч болон даатгалын мэргэжлийн

оролцогчоос тайлан, мэдээ, өргөдөл гаргах заавар”-ын 3 дугаар хавсралтад заасан “МАЯГТ СЗХ04107. Ердийн даатгалын компанийн нөөц сангийн тайлан”-ын 7 дугаар мөрөнд заасан “Тусгай нөөц сан” гэснийг баталгааны болон бусад гэж ангилан оруулах, мөн зааврын 44 дүгээр хавсралтад заасан “Даатгалын компанид мөрдөх дансны жагсаалт”-д “Тусгай нөөц сан /361001/” гэснийг “Баталгааны тусгай нөөц сан /361001/ болон Бусад тусгай нөөц сан /361002/” гэж, “Тусгай нөөц сангийн өөрчлөлт /661001/” гэснийг “Баталгааны тусгай нөөц сангийн өөрчлөлт /661001/ болон Бусад тусгай нөөц сангийн өөрчлөлт /661002/” гэж тус тус өөрчилсүгэй.

6.Энэ тогтоол батлагдахаас өмнө гаргасан даатгагчийн баталгааны хувьд баталгааны нөөц санг энэ тогтоолын 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргачлалын дагуу тооцоолон нөхөж байгуулж, баталгааны нөөц сангийн эхний үлдэгдлээр бүртгэхийг даатгагч нарт үүрэг болгосугай.

7.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын албанд даалгасугай.

ДАРГА

Т.ЖАМБААЖАМЦ